



АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	3
1.3. 2024 ОНД ЯВАГДАХ УУЛЫН АЖИЛ, УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ	5

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ 8

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 9

3.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	9
3.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	9
3.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
3.4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 12

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 13

5.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	13
5.2. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	15
5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	53
5.4. УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	19
5.5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
5.6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
5.7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
5.8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
5.9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
5.10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
5.11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	27
5.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
5.13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
5.14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	31



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол
- Хүснэгт 2. Уулын ажлын төлөвлөгөө
- Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим
- Хүснэгт 4. 2024 онд ажиллах тоног төхөөрөмж
- Хүснэгт 5. Элс угаан баяжуулах үйлдвэрийн хүчин чадал төлөвлөлт
- Хүснэгт 6. Ашиглалтын хугацааны ус хэрэглээ
- Хүснэгт 7. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд
- Хүснэгт 8. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 9. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд
- Хүснэгт 10. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд
- Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 14. Уурхайгаас сард ялгарах ахуйн бохирын тооцоо
- Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь /2024 он/
- Хүснэгт 19. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв



1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Талбайд 1986-1990 онд С.Гүрцоо, Д.Телеу нар 1:200000 масштабтай геологийн зураглалын ажлыг хийжээ. Энэ судалгааны дүнд геологийн карт зохиож, алт, ховор металл, зэс, молибден, вольфрамит, цагаан тугалга, төмөр, хайлуур жонш, өнгөт чулуу, барилгын материалын илэрц нээж, нутаг дэвсгэрийн металлогенийн төрх төлөвт мезозойн магматизм онцгой үүрэгтэй болохыг тогтоосон байна. Түүнчлэн С.Гүрцоо, Д.Телеу нар девон, карбоны настай тунамал чулуулгийг давхраасуудад ялгаж, ойролцоо газруудад алтны сарнилын хүрээ зурж, бусад ашигт малтмалын зүй тогтлын талаар тойм мэдээлэл өгсөн.

Орхоны талбайд А. Ганболд, Н. Энхцогт нар 1993-1996 онд 1:50000 масштабтай геологийн эрэл зураглалыг явуулж ашигт малтмалын талаар алтны орд байж болох дэвсгэр элементүүдийн зүй тогтлыг нарийвлан судалсан байна. Энэ судалгааны явцад урьдчилан гаргасан мэдээллийг үндэслэн Монгол Газар ХХК-ийн геологчид 1998 оноос эхлэн хайгуулын ажлыг явуулж ирсэн байна.

“Монгол Газар” ХХК-ний геологийн алба нь 1998 оноос эхлэн геологи- хайгуулын нарийвчилсан судалгааг тус талбайд явуулснаар Хангайн нурууны синклиналийн бараг төвийн хэсэг болох энэ нутагт Өлийн голын алтны хүдрийн зангилааг шинээр нээн, түүний бүлэг ордуудыг (Харгуйтын баруун салаа орд) судалж, алтны нөөцийг тогтоосон. Уг ажилд “Монгол Газар” компанийн геологичид болох Д.Баатар, Л.Батчулуун, Н.Баярсайхан, Н.Пүрэвдорж, минералогич Ж.Баярсайхан, өрмийн бригадын ахлагч төрийн соёрхолт Т.Баяраа, Б.Баянмөх, Энхбаатар, Б.Батмөнх нар ажилласан.

Уулын ажлын төлөвлөгөөний төсөл хийгдэж буй “Харгуйтын баруун салааны” ордод “Монгол Газар” ХХК нь өөрийн хөрөнгөөр хайргуулын ажил хийж нөөцийг химийн цэврээр /В+С/ 806.2 кг-р тооцон 2006 оны 3-р сарын 02-ны өдөр АМХЭГ-ийн Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулсан байна.

Энэ орд нь Улаанбаатар хотоос 500 км зайд орших ба бага зэргийн уул техникийн хүндрэлтэй боловч дундаж агуулга өндөртэй, жигд тархалттай, жилийн 4 улиралд авто тээврээр чөлөөтэй зорчих боломжтой тул манай “Алтай Голд” ХХК 2007 оноос энэхүү ордын тусгай зөвшөөрлийг шилжүүлж авсан. 2016 онд Байгаль орчны үнэлгээний “Газар чандмань” ХХК -аар “Харгуйтын амны баруун салаа алтны шороо орд” төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан.

БОННҮнэлгээний нэмэлт тодотголыг “Саблайм” ХХК боловсруулж БОАЖЯ-аар 2024 оны 06 сарын 27-ны өдөр баталгаажуулсан.



1.2.1 Төслийн байршил. Харгуйтын амны алтны шороон орд нь Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Улаанбаатар хотоос баруун зүгт 740 км, Өлийн голын хүдрийн дүүрэгт орших ба Хангайн уулархаг мужийн төвийн хэсэг, Орхон голын эх, ай сав газарт, байр зүйн зургийн L-47-48 хавтгайд байрлах бөгөөд засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт харъяалагдана.

Хүснэгт 1.

Төслийн талбайн байршлын солбицол

Цэгүүд	Уртраг			Өргөрөг		
	Градус	Мин	Сек	Градус	Мин	Сек
1	101	46	18.64	46	58	11.65
2	101	46	18.64	46	57	56.24
3	101	46	17.39	46	57	56.3
4	101	46	14.03	46	57	56.47
5	101	46	10.96	46	57	52.9
6	101	46	7.12	46	57	49.83
7	101	46	2.62	46	57	46.26
8	101	45	55.06	46	57	43.75
9	101	45	54.19	46	57	42.65
10	101	45	54.14	46	57	42.65
11	101	45	54.14	46	57	42.59
12	101	45	48.99	46	57	36.11
13	101	45	48.95	46	57	36.07
14	101	45	44.28	46	57	24.8
15	101	45	41.3	46	57	22.66
16	101	45	30.63	46	57	22.66
17	101	45	30.63	46	57	13.78
18	101	45	20.69	46	57	1.3
19	101	45	5.59	46	56	51.65
20	101	44	54.64	46	56	51.65
21	101	44	54.64	46	57	17.66
22	101	45	18.63	46	57	17.66
23	101	45	18.63	46	57	49.65
24	101	45	52.63	46	57	49.65
25	101	45	52.63	46	58	11.65
26	101	46	18.64	46	58	11.65



Зураг 1.Төслийн байршлийн зураг



1.3. 2024 ОНД ЯВАГДАХ УУЛЫН АЖИЛ, УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ

Олборлолтын үйл ажиллагааг экскаватор автосамосвалын хослол бүхий автотээвэртэй ашиглалтын системээр явуулах бөгөөд талбайд орхигдсон хоосон орон зай их учир дотоод овоолгоор дүүргэлтийн ажлыг явуулна.

Уулын ажлын төлөвлөлт. Харгуйтын баруун салаа ордын доод давхаргын 9-В блокоос хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг эхлэх бөгөөд цааш доод давхаргын 9-В, 10-В, 11-В, 12-В, 13-В блокуудад уулын ажлыг хийнэ. 9-В -ээс 13-В блокод 727.84 мян.м³ хөрс хуулж, 81.96 мян.м³ элс гаргана. Хөрс хуулалтын дундаж коэффициент 8.8, алтны дундаж агуулга 0.796 гр/м³ байна.

Хүснэгт 2 .

Уулын ажлын төлөвлөгөө

Олборлолтын сарууд	Хэмжих нэгж	Ашиглалтын сарууд								
		4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	Нийт
Уулын цул	мян.м ³	78.8	104.5	104.5	98.4	104.5	104.5	108.5	62.4	687.4
Хөрс хуулалт	мян.м ³	68.8	89.6	89.6	85.5	89.6	89.6	93	58.22	663.92
Элс олборлолт	мян.м ³	10	15.9	15.9	14.9	15.9	15.9	16.5	7.28	102.28
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	6.88	6	6	6.62	6	6	6	7	6.22
Угаах элсний хэмжээ	мян.м ³	10	15.9	15.9	14.9	15.9	15.9	16.5	7.28	102.28
Дундаж агуулга	гр/м ³	0.72	0.72	0.72	0.72	0.72	0.72	0.72	0.72	0.72

Ажиллах горим: Алтны шороон ордын уулын ажлыг 3 сарын 15-ээс эхэлж 12-р сарын 10 хүртэл 270 хоног ажиллана. Уулын ажил хоногт хоёр ээлжээр ажиллах бөгөөд нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Хүснэгт 3.

Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Х.н	хэмжээ
1.	Жилийн ажиллах хуанлийн өдөр	хоног	270
2.	Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	5
3.	Засвар үйлчилгээ, цаг агаарын хүндрэл зэргээс түр зогсолт хийж болзошгүй өдрүүд	хоног	2
4.	Жилд ажиллах өдөр	хоног	150
5.	Хөрс хуулалтын ажлын хоног	хоног	130
6.	Элс олборлолтын ажлын хоног	хоног	120
7.	Элс угаах ажлын хоног	хоног	100
8.	Хоногт ажиллах ээлжийн тоо		2
9.	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
10.	Ээлжинд засварлах нийлбэр хугацаа	цаг	2



Уулын ажил. Харгуйтын баруун салаа ордын 8-В,8-С,9-В блокуудад хөрс хуулалтын ажлыг хийх ба доголын налуугийн өнцөг 65 градус, уурхайн ерөнхий хажуугийн өнцөг 58 градус байна.

Тоног төхөөрөмж. Алтны шороон ордын ухаж ачих ажилд Hyundai 520LC экскаватор 1 ш, элс олборлолтод Hyundai 3000LC экскаватор 1ш, хөрс болон элс тээвэрлэлтэд 11 м³ -ийн багтаамжтай автосамосвал 7 ш, бункер тэжээх ажилд 3.0 м³ ийн шанаганы багтаамжтай утгуурт ачигч 1 ш, овоолго дээр CAT D11 маркийн бульдозер 1 ш, CAT D6 маркийн бульдозер 1 ш тус тус ашиглана.

Хүснэгт 4.

Техник тоног төхөөрөмж

Техникийн нэр төрөл			Тоо	Хийж гүйцэтгэх ажил
1.	Экскаватор	Hyundai Robex 520 LC	1	Хөрс хуулалт
2.	Экскаватор	Hyundai Robex 3000 LC	1	Элс олборлолт
3.	Бульдозер	CAT D11	1	Овоолго
4.	Бульдозер	CAT D6	1	Овоолго
5.	Автосамосвал	North benz	7	Тээвэр
6.	Утгуурт ачигч	ZL 50	1	Баяжуулалт
7.	Угаах төхөөрөмж	80 м.куб	2	Баяжуулалт
Нийт			14	

ЭЛС БАЯЖУУЛАЛТЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ. “Ар чулуут-1” алтны шороон ордын угаалга баяжуулалтын ажил 2024 оны 04 сарын 01-ээс эхлээд 11 сарын 01 –н хүртэл явагдах бөгөөд энэ хугацаанд нийт 81.96 мян.м³ алт агуулсан элсийг угааж баяжуулахаар төлөвлөж байна. Алтны шороон ордын элсийг угаан баяжуулах ажилд нэг шугам сууриллуулахаар төлөвлөж байна. Шугамын хүчин чадал 80 м³/цаг хүчин чадлаар ажиллана. Элс угааж баяжуулах шугамуудын ажиллах хугацааны горимыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5.

Элс угаан баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын төлөвлөлт

№	Үзүүлэлт	2024
1.	Төслийн нийт хуанлийн өдөр	184
2.	Төслийн нийт хуанлийн сар	6
3.	Сарын хуанлийн хоног	31
4.	Сард ажиллах хоног	31
5.	Өдрийн хуанлийн цаг	24
6.	Цаг ашиглалт, %	92
7.	Өдөрт ажиллах бодит цаг	22
8.	Сард ажиллах бодит цаг	682
9.	Цагийн хүчин чадал, м ³ /цаг	80
10.	Төслийн хүчин чадал	195,840



ТУНААХ НУУР. Баяжуулах үйлдвэрээс гарсан хаягдлыг гадаргын дагуу урсгах тусгайлан бэлдсэн хашлага бүхий сувгаар урсган тунгаах нуурт цуглуулах бөгөөд тунгаах нуурт цугларсан булингыг тунгааж, тунасан хэсгийг цэвэр усны нуур луу насосоор татаж дахин ашиглана. Тунаах нуурыг ус нэвчихгүй материал ашиглан доторлоно. Нууран дахь ус шаврын холимогийг тунгааж, усыг насос ашиглан соруулсаны дараа тунадасыг экскаватороор гаргаж авна.

ЦАХИЛГААН ХАНГАМЖ. Архангай аймгийн цэнхэр сумын нутаг Орхон Чулуут голын бүс нутагт дэд бүтэц сайн хөгжөөгүй, өндөр хүчдэлийн, цахилгаан шугам тавигдаагүй. Уурхайн цахилгаан хэрэглээг дизель генератороор хангах тул уурхайн цахилгаан зарцуулалт нь түлшний зардалд орох юм.

ТЕХНОЛОГИЙН УСАН ХАНГАМЖ. Харгуйтын ордын төв хэсэг гидрогеологийн нөхцөлийг судлах зорилгоор УКС-22 цохилтот өрмөөр Ш-58 -ийн 14 -р цооногийг 12.0 м-ийн гүнтэй өрөмдөж, 3.6-6.0 м-т 8.5-12.0 м-т тус тус ан цавын усны үе илрүүлж, шавхалт туршилтын ажил явуулахад статистик түвшин нь 1.2 м, ундрага 2.2 л/сек, уст үеийн зузаан (2 үе) 5.9м, ус агуулагч нь ан цавчлагдсан, хагаралтай цахиурлаг элсэн чулуу бөгөөд цэвдэггүй гэж тогтоосон. Байгаль орчноо хамгаалах болон цэвэр усны нөөцийг хэмнэх үүднээс үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх өмнө олборлолт явуулсан талбайд хуримтлагдсан тогтсон нуурын уснаас хангахаар төлөвлөсөн болно.

Харгуйтын баруун салааны шороон ордын хувьд алт олборлож буй үйлдвэрүүдийн туршлага болон өөрийн практик туршлага дээрээ үндэслэж угаалгын ажлыг хийх мөн технологийн тооцооллын дагуу тооцож үзэхэд хэрэглээний усныхаа 70-80% -ийг буцаан ашиглах буюу эргэлтийн усаар хангах ба нэмэлтээр 20-30 % -ийг цэвэр усны эх үүсвэрээс авч хэрэглэхээр төлөвлөсөн болно.

Харгуйтын баруун салааны шороон ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай болох нь технологийн туршилтын үр дүнд тогтоогдсон ба технологийн тооцооллын дагуу 1 м³ элс угаахад 4.0 м³ ус хэрэглэхээр байна. Тусгай зөвшөөрлийн талбайд өмнө үйл ажиллагаа явуулж байсан “Монгол Газар” ХХК-ны үүсгэсэн үүсмэл нуурыг дахин сэлбэж ашиглана. Үүнд уурхайн карьераас шүүрсэн усыг зумфпэд цуглуулж насосоор татан цэвэр нуур луу цугтах бол угаах төхөөрөмжөөс гарсан гаалийн хаягдлыг тунаах нуурт цуглуулж тунгаан тунасан усыг мөн нуур луу насос ашиглан татаж дахин ашиглана.



ДЭД БҮТЭЦ, ЗАМ ХАРИЛЦАА. Улаанбаатар хотоос Архангай аймгийн Цэнхэр сум хүртэл 438 км хатуу хучилтат замтай ба Харгуйтын баруун салаа орд нь Цэнхэр сумтай 80 км шороон замаар холбогдсон. Тус сум нь шуудан холбоо, 12 жилийн сургууль, 14 ортой эмнэлэг болон үйлчилгээний төвтэй. Уурхайн талбайгаас лагер хүртэл 0.5 км зайтай. Ордын ойролцоо Өлзийт тээл, Баруун Сөдөтийн ордууд дээр “Алтан Дорнод Монгол” болон Гацуурт компаниуд үйл ажиллагаа явуулдаг.

Тус бүс нутагт зун цагт шавар, намаг ихтэй байдгаас үүдэн автомашинаар зорчиход багагүй хүндрэл учирдаг байсан хэдийч “Монгол Газар” ХХК нь Өлийн давааны замыг засаж сайжруулсан байна. Архангай аймгийн төв Цэцэрлэг хот нь Улаанбаатар хотоос 490 км бөгөөд хатуу хучилттай замаар холбогдсон. Цэцэрлэг хотоос Цэнхэр сум хүртэл 25 км хатуу хучилттай замаар холбогдсон. Цэцэрлэг хот нь шилэн кабель, сургууль, цэцэрлэг, 60 ортой нэгдсэн эмнэлэг болон үйлчилгээний төвтэй.



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ

Уур амьсгал. Энэ бүс нутагт хүйтний улиралд баруун хойноос ирэх эсрэг циклон, дулааны улиралд баруун өмнөд талаас ирэх циклоны урсгалын нөлөөнд орших тул жилийн аль ч улиралд эдгээр урсгалууд холимог долгион үүсгэнэ. Энэхүү үзэгдэл нь Хангайн нурууны өндөрлөг газарт тундасны хуримтлал илүү их явагдаж, ууршдагаас хур тунадас элбэг байдаг. Жилийн тунадас хуримтлал 258 мм бөгөөд үүний 90% нь зуны улиралд орж голуудыг тэжээдэг болно. Өвөлд өндөр уулын бүсээр 10-20 см зузаан цас ордог. Агаарын дундаж чийглэг 58%, температурын хамгийн их нь зуны улиралд +25°, хамгийн бага нь өвлийн улиралд -31°C хүрнэ.

Уулзүй. Ордын талбайн орчмоор хамгийн өндөр цэг нь далайн түвшнөөс дээш 2682.0 м өндөр Цагаануул, 2735.0 м өндөр Ар Улаан чулуут уул, хамгийн нам цэг нь Өлзийт голын савд 2010.3 м өргөгдсөн хөндий толгодорхог хэсэг болно. Нийт талбайн 80%-г 2200 м-с дээш өргөгдсөн уулс эзлэх ба ерөнхийдөө бөмбөгөр оройтой, эгц хажуутай. Шинэ төрмөлийн сүүлийн галавт болсон мөстлөг уулсын тогтцод гүн ул мөр үлдээсэн. Энэ үетэй холбоотой мөстлөгийн дэнжүүд болоод нарийн хавцлууд тохиолдоно. Уулсын оройгоор мөстлөгийн морен элбэг тааралдана. Мөн неогений базальтаар бүрхэгдсэн оройтой 2445.0 м өндөр Хөх хавцгай, 2245.0 м өндөр Хэцийн дөрөлж 2567.0 тоот өндөрлөгүүдийн дунд байрлана.

Ус зүй. Судалгааны талбай нь Хангайн нурууны томоохон голуудын нэгэн болох Орхон голын цутгал голуудтай Хангайн нурууны өврөөс эх авч талбайн баруун урдаас зүүн, зүүн хойш дайран өнгөрөх Орхон голд цутгах хүртэл Өлийн голд Өлзийттээл, Улаанчулуут, Гүүт, Билчир зэрэг байнгын урсгал устай олон ам жалга нийлдэг. Эдгээр нь тунгалаг устай, голын өргөн нь 1.5-10 м, гүн нь дунджаар 0.96 м ус нь гидрокарбонат найрлагатай байна.

Ургамал, амьтан. Энэ нутагт ургамлын бүрхүүл, ан амьтан элбэгтэй. Талбайн нилээд хэсэг нь ойгоор бүрхэгдсэн ба энд хармод, хус, хуш, шинэс, голчлон ургасан байдаг. Голын хөндийгөөр янз бүрийн бутлаг ургамал ургана. Амьтдаас буга, бор гөрөөс, нохой зээх, чоно, гахай, шилүүс, тарвага, мэргэчид, төрөл бүрийн шувууд бий. Голууд нь хайруус, зэвэг, цурхай зэрэг загастай.



ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үндсэн 2 нөлөөлөл байна. Үүнд:

- > Уурхайд ашиглагдаж байгаа машин механизмаас ялгарах бохирдуулагч бодисууд
- > Уулын ажил болон төслөөс шалтгаалан үүссэн ил уурхай, хөрсний овоолго, зам зэрэг ил гадаргуугаас тоос үүсэх

Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжөөс агаарт цацаргдах хорих бүхий бүхий утаа тортог нь ихэвчлэн хөдөлгүүр дэх бензин, дизель түлшний дутуу шаталтаар бий болно. Үүнд хамгийн нийтлэг бохирдуулагч бодисууд нь CO, NO₂, SO₂, хөө-угаа тортог орно. Зарцуулсан түлшний 15% нь хөдөлгөөнд зарцуулагддаг бол үлдсэн 85% нь агаарт химийн нэгдэл хэлбэрээр замхарч тархдаг байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэхь түлшний дутуу шаталтаас агаарт ялгарах хортой хийн зонхилох хувийг азотын нэгдлүүд эзэлдэг. Энэ бохирдуулагч бодисууд нь агаарын чанарыг муутгаж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

Ордын ашиглалтын үндсэн процессууд болох хөрс хуулах, элс олборлох, хөрсний гадаад болон дотоод овоолго байгуулах, элс баяжуулах зэрэг үйл ажиллагаанаас болон ил уурхайн ухаш, гадаад хөрсний овоолго зэрэг эвдрэлд орсон талбайн гадаргуугаас орчны агаарт тоос босно. Агаар орчинд тархах тоос, тоосонцор болон бусад төрлийн эгэл хэсэг нь хүндийн хүчний нөлөөгөөр газрын гадаргад бууж хөрс, ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

3.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Өлтийн дээд хэсгийн алтны шороон орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас технологийн үйл ажиллагаа болон ажилчдын усан хангамж, зам талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ус хэрэглэнэ. Тус уурхайн алт ялгаж байгаа технологийн гол хэрэгсэл нь ус бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь технологийн хэрэгцээнд ус ашиглах явдал юм.

Олборлосон элсээ угаах төхөөрөмжинд оруулж усаар угаахад хүндийн жин ихтэй учир алтны жижиг хэсгүүд доош тунаж үлддэг. Эрдэс болон нарийн ширхэгтэй элс шавар агуулсан, булингар ихтэй хаягдал ус тунгаагуур луу ордог. Ашиглаж буй усаа хэд хэдэн үе шаттай тунгаагуурт тунгааж, цэвэрлэх хэдий ч эргэлтийн усан санд ихээхэн хэмжээний хагшаасны хуримтлал үүснэ.

Бохир усаар хөрс, ус бохирдуулахгүй байх шаардлагатай ба тунгаагуурын урт, өргөн, гүн, тунах хугацааг тооцсон гидравлик тооцоо үндэслэлгүйгээр тунгаагуур буюу эргэлтийн усан санг байгуулвал усан сан халих, далан эвдрэх, сэтрэх зэргээр шаварлаг, булингар, хагшаас ихтэй бохир ус алдагдаж болзошгүй.



Уурхайд ашиглаж байгаа машин техникүүдээс шатах тослох материал асгарах, ажилчдын санамсар болгоомжгүй байдал, техник хангамжийн бүрэн бус байдал, шатахууныг цэнэглэх явцад асгарсан тохиолдолд хөрс бохирдож, гадаргын урсацын шүүрэлт нэвчилтээр газрын доорхи усны чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Баяжуулалтанд ашиглаж буй эргэлтийн усан сангийн усыг ямар нэгэн тохиолдлоор шатах тослох материал болон бусад бохирдуулагч бодисоор бохирдуулсан тохиолдолд бохир усаар дамжин хөрс, газрын доорхи ус бохирдох эрсдэлтэй.

Уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээнээс бохир ус гарах бөгөөд стандартын дагуу цэвэршүүлж, саармагжуулалгүй хөрсөнд асгасан тохиолдолд хөрс бохирдуулаад зогсохгүй газрын доорхи усыг бохирдуулж болзошгүй юм.

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй. 2024 онд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээ, унд ахуйн усан хангамж, тоос дарах болон усалгаанд зэрэгт 521,25 мян.м³ ус хэрэглэхээр байна.

Хүснэгт 5.

Ашиглалтын хугацааны ус хэрэглээ

Д/д	Усны зардал	Хэмжих нэгж	2024 он
1.	Технологийн сэлбэх усны хэрэгцээ	Мян.м ³	316,39
2.	Ахуйн болон бусад усны хэрэгцээ	Мян.м ³	1,794
3.	Усалгааны хэрэгцээ	Мян.м ³	3,2
Нийт жилийн усны хэрэгцээ		мян.м³	521,25

3.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас нийтдээ 14,37 га талбай бүхий аллювийн намагт хөрс, хар хүрэн хөрс нөлөөлөлд өртөнө. Алтны шороон орд нь хэвтээ тогтоцтой, бага гүнтэй байдаг учир хөрс хуулалт, элс олборлолтонд өртөх талбайн хөрсөн бүрхэвч ухагдаж эвдрэн хөрсний механик бүтэц холидоно.

Уурхайн тосгон, баяжуулах үйлдвэр, уурхайн дотоод зам гэх мэт барилга байгууламжийн улмаас хөрсний өнгөн хэсэг буюу ялзмагт давхарга устана. Ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдсоны улмаас газар доорх усыг бохирдуулах эрсдэлтэй. Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөр шороон зам үүсч хөрс эвдэрч талхлагдах, хөрсний гадарга хэт нягтрах, ховил гуу үүсгэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч, үүнээс улбаалан ургамлын төрөл зүйл цөөрөх, устах, бүрхэц багасч тоосжилт ихээр босох нөхцөл бүрдэнэ.

Уурхайн автомашинуудын шатах тослох материалын хэрэглээ болон хадгалалтын явцад нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд асгарсан тохиолдолд хөрс, ургамал бохирдож, газрын доорхи усанд нэвчиж, бохир уснаас уусан хүн болон мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлж болзошгүй. Учир нь нефтийн бүтээгдэхүүнд төрөл бүрийн хортой хүнд металл болон органик бодис агуулагддаг. Мөн ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох нөлөөтэй.



Хог хаягдалд төрөл бүрийн бохирдуулагч бодисууд агуулагдаж байхаас гадна ахуйн бохир усанд халдварт өвчин үүсгэгч нян, бактери байдаг бөгөөд бохир усаар хөрс бохирдож, улмаар мал амьтан, газрын доорхи ус бохирдуулах эрсдэлтэй.

3.4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Алт олборлох төслийн хүрээнд олборлолтонд өртөх, хөрсний овоолгод дарагдах, баяжуулах үйлдвэр, тосгон, уурхайн дотоод зам бусад барилга байгууламжийн улмаас үүссэн хөрсний эвдрэлийг дагаж ургамлан нөмрөгийн талхлагдал, доройтол үүснэ. Олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтонд ойролцоох талбайн ургамлан нөмрөг өртөж ургамлын фотосинтезийн процесс удааширч багтрах, ургамлын гадарга, навч түлэгдэх сөрөг нөлөөтэй.

Уурхайд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад болон жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, тоо толгой нь цөөрөх магадлалтай. Хөрс ухах, элс олборлох үндсэн үйл ажиллагаа нь хөрсөнд амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчидийн амьдрах орчинг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлж болзошгүй.

Уурхайн автомашинуудын шатах тослох материалын хэрэглээ болон хадгалалтын явцад нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд асгарсан тохиолдолд хөрс, ургамал бохирдож, газрын доорхи усанд нэвчиж, бохир уснаас уусан хүн болон мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлж болзошгүй. Учир нь нефтийн бүтээгдэхүүнд төрөл бүрийн хортой хүнд металл болон органик бодис агуулагддаг. Мөн ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох нөлөөтэй.

Хог хаягдалд төрөл бүрийн бохирдуулагч бодисууд агуулагдаж байхаас гадна ахуйн бохир усанд халдварт өвчин үүсгэгч нян, бактери байдаг бөгөөд бохир усаар хөрс бохирдож, улмаар мал амьтан, газрын доорхи ус бохирдуулах эрсдэлтэй.



ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

Энэхүү төлөвлөгөөгөөр алт олборлолтын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарийг тогтоож өгөв.

Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдаатай бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацааны туршид агаар, гадаргын болон газар доорхи ус, хөрсний чанар, ургамал, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох, түүний болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж шаардлагатай арга хэмжээнүүдийг байгаль хамгаалах төлөвлөгөөнд нэмж тусгалаа.

Байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОНХАЖЯаманд ирүүлэх бөгөөд жилд 1 удаа орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулахаар тусгалаа



ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай. Байгалийн нөөцүүд тус бүрээр нь ангилан авч үзлээ.

5.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Автомашины хөдөлгөөнөөр сул хөрстэй хөрсний өнгөн үе давхарга элэгдэж тоос босох нөхцөл бүрддэг тул уурхайн дотоод замыг засч сайржуулна. Уурхайн дотоод замаас босох тоосыг багасгахдаа 2 л/м^2 нормоор салхитай, хуурайшилт ихтэй үед уурхайн зам усалгааг тогтмол хийж, чийгшүүлнэ.
2. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийж, чанар сайтай шатах тослох материал, утааны шүүлтүүр ашиглах, утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийнэ.
3. Сонсголыг хамгаалах нийлэг бөглөө 10-20 дБА, чихэвч 20-40 дБА нь дуу шуугианыг багасгаж чаддаг тул хамгаалах хэрэгслийг бутлалт зэрэг шуугиан ихтэй газарт ашиглах замаар ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор хамгаалах хэрэгслээр хангах
4. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтмол хянаж, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх.
5. Олборлолтын явцад үүссэн тоосжилт нь талбай дахь ажлын нөхцлийг муутгах улмаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөллөг тул ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах, хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх шаардлагатай.



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ

Хүснэгт 7.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хөдөлгүүр дэх түлшний дутуу шаталтаас их хэмжээний хорт хий ялгарч, агаарыг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.	Тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийж, чанар сайтай шатах тослох материал, утааны шүүлтүүр ашиглана.	Төсөлд ашиглагдаж байгаа машин механизмуд	Тоо ширхэг	-	13	1.5	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт
2.		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө							Агаарын Бохирдлын Тухай Хууль 4.1, 4.1.4, 7.3
3.	Тоос тоосонцор нь хөрс болон ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөтэй, мөн салхиар зөөгдөж газар орчмын агаарыг бохирдуулж экосистемд сөрөг үр дагавартай.	Салхи, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг багасгахдаа 2л/м ² нормоор өдөрт 2-оос доошгүй удаа усална. Усалгааны машин механизмаар хангана.	технологийн дотоод, гадаад замууд		-	-	Усны зардал тусгав	Төсөл хэрэгжих хугацаанд	Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм, БОНХАЖС 2015.07.30-А/301 тушаал 13 хавсралт
4.	Хөрс хуулах, элс олборлох, тээвэрлэх зэргээс тоос босч агаар бохирдох, машин механизмын хөдөлгүүрээс хорт хий ялгарах тул хяналт шинжилгээг тогтмол явуулах	Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, физик бохирдлыг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав						Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, (MNS4585:2016)
Нийт зардал							1.5		



5.2. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- Шинээр ундны усны эх үүсвэрийг хайж олох, ундны стандартад нийцсэн усыг уурхайн ажилчдыг хангах, ашиглалтанд орсны дараа эргэн тойронд 5-10 м зайнд онцгой болон эрүүл ахуйн хориглолтын хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын хайс босгох болон бүсийн дэглэмийг мөрдөнө.
- Мэргэжлийн байгууллагатай хамтран хаягдлын болон тунгаах нууруудын далангийн бат бэх байдлыг хангаж, шүүрэлт, нэвчилтээс хамгаалж ажиллана.
- MNS 5924:2008 "Нүхэн жорлон, бохир усны нүх"-ний ерөнхий шаардлага хангасан ажилчдын бие засах газрыг байгуулна.
- Ахуйн бохир ус, шатах тослох материал асгарснаас хөрс бохирдон улмаар газрын доорх ус бохирдох тул асгарсан, нэвчсэн тохиолдолд бохирдлыг даруй арилгаж, саармагжилтыг цаг алдалгүй хийсний дараа төлөвлөгөөт хугацааг хамааралгүй дээж авч шинжлүүлнэ.
- Газрын доорх усны чанар нь MNS 0900:2005 стандартыг хангаж буйг хянах зорилгоор ундны ус, ундны усны савны усанд микробиологийн болон химийн ерөнхий шинжилгээг тогтмол хийлгэнэ.
- Усны нөөц, хомсдлыг бууруулах зорилгоор технологид ашигласан бохир усыг MNS 4943:2015 стандартад хүргэн цэвэрлэн, дахин ашиглах цэвэрлэсэн ус, технологийн ерөнхий шаардлага /MNS 6734:2018/-д нийцсэн усыг технологийн усны хэрэгцээнд болон зам усалгаанд ашиглах боломжийг мэргэжлийн компанитай хамтран авч хэрэгжүүлэх хэрэгтэй.



**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ**

Хүснэгт 8. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг					
										Ү/а-ны зардал	0.2	Удирдлага зохион байгуулалтын зардалд тусгав	3.0	3.0
1.	Алттай элснээс алтыг салгахын тулд ихээхэн хэмжээний ус ашиглаж усны нөөц хомсдох, усны чанар муудаж булингартуулна.	Усны газараар ус ашиглуулах дүгнэлтээ гаргуулж, Орхон-чулуут голын сав газрын захиргаатай /ОЧСГЗ/ гэрээ байгуулан, ус ашиглах төлбөрөө төлнө. Технологийн нийт усны хэрэглээ 36448м ³ , уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ 1530м ³ , гадаад болон дотоод нийт зам 28.8м ² талбайн тоосжилтыг дарах ус 1728м ³ , 1га талбайд биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэрэглээнд 160.0м ³ ус ашиглаж нийт 37978м ³ .	Хаягдлын сан, тунгаах нуур болон голын ус				Өмнөх жилүүдэд суутгасан Барьцаа хөрөнгөөр суутгана	Төсөл хэрэгжих явцад	MNS 4943:2015 Усны чанар. Хаягдал ус MNS 4586:1998 Усны байгаль орчны чанар, Ерөнхий шаардлага Усны тухай хууль, ус бохирдуулсны тухай хууль,					
2.		Үерийн ус орохоос сэргийлэх, уурхайн далан сэтэрч эргэлтийн ус алдахаас хамгаалах								Ү/а-ны зардал				
3.		Хаягдлын санд хуримтлагдсан хагшаасыг намар зайлуулна.											0.2	
4.	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах эрүүл ахуйн бүсийг тогтоож, ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус хөрсөөр дамжин газрын доорх ус бохирдох аюултай	Ундны усны эх үүсвэр, нөөцийг тогтоох, эхийг хамгаалах арга хэмжээ авах, ундны усны чанарыг сайжруулах цогц арга хэмжээ	Уурхайн тосгон, гүний худаг, бохирын цооног			3.0	3.0	Төсөл хэрэгжих явцад	УТХ 24.2, 24.5. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг авч усны мэдээллийн санд бүртгүүлнэ.					
5.		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.												
6.	Унд, ахуйн хэрэгцээний бохир усыг хаях, агуулах савыг холбогдох журам, стандартын дагуу шийдэх	Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчихгүй байхад анхаарч тогтмол хугацаанд бохирыг соруулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авна	Карьерын ус, гал тогооны болон халуун усны газрын саарал ус				0.5	Төсөл хэрэгжих явцад	MNS 0900:2005 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, Ундны ус, эрүүл ахуйн шаардлага ба чанарын хяналт, MNS 6734:2018					
7.		Хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл авч, мэдээллийн санд бүртгүүлнэ											0	
8.	Ахуйн болон технологийн усыг цэвэршүүлэх арга хэмжээ авах нь усны нөөцийг хэмнэх, хомсдлоос багасгах арга хэмжээ болно	Хаягдал усыг цэвэршүүлэх, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэх	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх				1.0	Төсөл хэрэгжих явцад						
9.	Уурхайн ашиглалтын явцад ашигласан ус	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх								Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав				
Нийт зардал						4.7								



5.3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Гадаад овоолго хийх талбайг үржил шим багатай, байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарч ажиллана.
- Замгүй газраар тээврийн хэрэгсэл явж талхагдал үүсгэх гол нөхцөл болдог тул үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тээврийн хэрэгслүүдийн уурхайн нэгдсэн замаас өөр газраар явуулахгүй байх.
- Газрын гадарга хөрсийг элэгдлээс хамгаалахын тулд уурхайчдын тосгон орчимд мод, сөөг, олон наст тарих, уурхайн эргэн тойронд хөрсний элэгдлээс хамгаалах арга хэмжээ тогтмол авч ажиллана.
- Уурхайн ашиглалт хийж дууссан хэсгийн малталт болон дотоод овоолгуудыг тараан тэгшлэж, хэлбэржүүлэн, нягтаршуулан хөрс чулуулгийг доош суух, цөмрөх зэрэг эвдрэлээс хамгаалан, нөхөн сэргээх ажлыг стандарт журмын дагуу чанартай хийж гүйцэтгэхэд онцгой анхаарч ажиллана.
- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх
- Газрын гадаргуугийн хэлбэр дүрсийг анхны төрх байдалд нь ойртуулан засах тал дээр онцгой анхаарч ажиллана.
- Уулын техникийн засвар үйлчилгээний талбайг усны урсгал орохоос Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгүүдийг төлөвлөн байршуулах



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ

Хүснэгт 9. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Хугацаа ба давталт	Зардал /сая.төг/	Баримтлах стандарт, аргачлал	
1	Газар ашиглах гэрээний дагуу, газрын төлбөр төлөх	Компанийн захирал	Үйл ажиллагааны хугацаанд	6.5	MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага MNS 5917:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 ХАА-н үрэлгээний норм, норматив, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах" MNS 5918:2008 Мод тарих, суулгах ажлын норм норматив, стандартууд	
2	Уулын ажилтай зэрэгцэн дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж техникийн нөхөн сэргээлт хийнэ. Шимт хөрсийг хамгаалж хэлбэршүүлэх,	Уулын инженер		Техникийн нөхөн сэргээлтийг дотоод зардлаар гүйцэтгэнэ		
3	Уурхайн олборлолт тээвэрлэлтийн зам засах	Уулын инженер		4.7		
4	Шатах тослох материалын алдагдлыг хянах, асгарсан үед хэрэглэх материалыг шаардлагатай газруудад байршуулна. /Шатахуун хадгалах сав, дамжуулах хоолой, дизель станцын орчимд/	Түлшний нярав, БО	Үйл ажиллагааны хугацаанд	ОХШХ-т тусгав	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм. БНБД 21-02 -02 Агуулахын барилга. БНБД 31-19-10, 2010	
5	Шатах тослох материал хадгалах сав, талбайн доор хамгаалалтын суурь хучилт хийнэ.					
6	Засварын газар, сэлбэг хэрэгслийн 400м2 талбайг бетондож, хатуу хучилттай болгох.	Уурхайн дарга	Үйл ажиллагааны хугацаанд	Үйл ажиллагааны дотоод зардлаар гүйцэтгэнэ.		
7	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэнэ	БО	Үйл ажиллагааны хугацаанд	ОХШХ-т тусгав		
Нийт зардал				11.2		



5.4 УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж эвдрэх талбайн өнгөн хөрсийг 0.6 м зузаантайгаар хуулан стандартын дагуу хадгална
- Нөхөн сэргээлтэнд тус бүс нутгийн унаган ургамал, бут сөөгийг ашиглах, ургах чадвар сайтай, нөхөн сэргээлтэнд ашиглахад тохиромжтой нутгийн ургамлуудыг сонгон шалгаруулах, үрийн нөөц бэлтгэнэ.
- Уурхайн тосгоны хашаанд мод, олон наст ургамал, зүлэг тарина.
- Бидний олон жилийн ажиглалтаар хогийн цэгт үнэг, хярс, хүнд ойромсог шувууд ирж хооллодог болох нь ажиглагдсан тул хогийн цэгийг ариун цэврийн журмын дагуу байгуулж, амьтан муудсан хоол идэх, өвчлөхөөс сэргийлэн ажиллана.
- Биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, сумын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, санал солилцох, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлнэ.
- Уурхайд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбайгаас дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарч болзошгүй тул дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмжүүд ашиглана.
- Ажлын шаардлагаар ухсан нүх, цооногт хүн, мал, зэрлэг ан амьтан орохоос сэргийлсэн хамгаалалтын түр хашаатай байлгах, ашиглалтын дараа ухсан нүх цооногийг газрын байдалд тохируулан тэгшилнэ.
- Мэргэжлийн байгууллага болон амьтан судлаачтай хамтран амьтны мониторингийн бүрэн судалгаа хийж, уурхайн ажилчдад хууль бус ан хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэхгүй байхыг анхааруулж, байгаль хамгаалах талаар сургалт явуулна.
- Ус намгийн амьтдын амьдрах, буудаллаж амрах, үржих газрыг хөндөхгүй байх, усны ундаргыг нь дэмжих арга хэмжээ авна.
- Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, ус, хөрс, бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.
- Хөрс ухах, элс олборлох үндсэн үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавьжийн зүйлийн бүрдэл, хөрсний микроорганизмуудын тоо толгойг бууруулах, амьдрах орчинг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлж болзошгүй тул анхаарч ажиллана.
- Хоол хүнс, ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг синантроф шувууд цуглаж болзошгүй. Төслийн үйл ажиллагаанаас ургамал амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг доорх хүснэгтэнд харуулав.



Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж			Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ				
1	Хөрс хуулалт, олборлолтын явцад хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтолд орно	Шимт хөрсийг ургамалжуулж түүн дотор ургалт эрхтний нөөцийг хамгаалах	Төсөл хэрэгжих болох нөлөөлөлд өргөх талбай	Үйл ажиллагааны зардал			Төсөл хэрэгжих хугацаанд	Монгол улсад мөрдөгдөж буй байгаль орчны хууль тогтоомж, бусад холбогдох хуулийн хүрээнд MNS 5914:2008. Байгаль орчин, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS 5918:2008 ХАА-н үрэлгээний норм, норматив, "эвдэрсэн газрыг ургамалжуулах" MNS 5918:2008 мод тарих, суулгах ажлын норм норматив, стандартууд БОННУ-2020	
2	Уулын ажлын техник ажиллагаа, хөрс хуулалтаар ургамал биет хэмжээгээр сүйтгэгдэнэ	Биологийн аргаар нөхөн сэргээлтийн талбайд бэлчээрийн идэмжит ургамлыг тарина.		Нөхөн сэргээлтийн зардал					
3	Уулын ажил, орчны газар ашиглалтын үед тээвэрлэлтээс тоосжилтоос үүсч, ургамлын ургамх орчин доройтно	Уулын ажлын газар ашиглалтыг ТЭЗҮ-д заасны дагуу хийж, илүү агазар эвдэхээс зайлсхийж, олон салаа зам үүсгэхгүй байх		Үйл ажиллагааны зардал					
4	Уулын ажил, орчны газар ашиглалтын үед тээвэрлэлтээс тоосжилтоос үүсч, ургамлын ургамх орчин доройтно	Тоосжилтыг бууруулах, шаардлагатай үед дотоод тээврийн замыг услах арга хэмжээ авна.		Усны зардалд					
5	Уурхайн машин механизмын дуу чимээнээс хээрийн, мэрэгч, орон нутгийн идээшилтэй бэлчээрийн хөхтөн амьтдын нутагшилд сөргөөр нөлөөлнө	Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархацыг тодорхойлох							1,0
6		Хууль бус хулгайн анг таслан зогсооход онцгойлон анхаарч ажиллана.							
		Орон нутгийн амьтан хамгаалах судалгааны ажилд дэмжлэг үзүүлнэ.				1,0			
		Холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалт явуулна.				1,0			
Нийт зардал						3,0			



5.5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Харгуйтын баруун салааны алтны шороон ордын ” уурхай нь 2024 оны ашиглалтын үйл ажиллагаа явцад газрын гадаргад 3,5 га шимт хөрс хуулж хадгалах 0,8 га газар эвдрэлд орох тул өмнө нь олборлолтод өртсөн талбайтай нийлээд 5 га-д техникийн нөхөн сэргээлт хийнэ. Хөрс хуулалт, олборлолтын ажлын явцад дотоод овоолгын ажил мөн нөхөн дүүргэлт, хэвгийжүүлэлтийн ажил давхар хийгдэнэ. Иймд техникийн нөхөн сэргээлтийн зардал нь үйлдвэрлэлийн зардалд орсон байна. БОННУ-гийн тайланд тусгаснаар төслийн 2 дах жилээс биологийн нөхөн сэргээлтийг эхлэн гэж тусгасан байна.

Байгаль орчин хамгаалах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж уурхайн дарга болон холбогдох төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулж түүний дагуу үйл ажиллагаагаа явуулна. Үүнд уулын ажилтай холбоотойгоор эвдрэлд орох хөрс, ургамлыг хамгаалах түүнд мониторинг хийх, ус агаарт дээжлэлт, хяналтын ажлыг явуулж шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 11.

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая. Төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн ухашийг дүүргэх	га	5		Ү/а-ны зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5917:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2008 ХАА-н үрэлгээний норм, норматив, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах" MNS 5918:2008 Мод тарих, суулгах ажлын норм норматив, стандартууд БОАЖС, ЭБЭХС-ын ахмтарсан тушаал уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газурын нөхөн сэргээх ажлын үнэлгээ тооцох аргачлал 2010.5.10.
		Талбайг тэгшлэх, хэвгүйжүүлэх	га	5				
		Орчны тоосжилтыг багасгах, услах						
2.	Биологийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт 2 дах жилээс эхлэнэ	га					
			га					
3.	Уухайн кемпийн ойр орчим мод тарих				2,0			
Нийт зардал					2,0			



5.6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННУ-ний тайланд “...Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах гэдгийг "төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.”Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс 2024 онд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт 500 ширхэг мод тарихаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 12.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1.	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах ажиллагааны ургамлын нарийвчилсан судалгааг хийх Ховрын статустай ургамлыг дүйцүүлэн хамгаалах газарт шилжүүлэн суулгах, тарималжуулах Амьтны аймгийн судалгааг нарийвчлан хийх	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд	2.0	2024 онд Төсөл хэрэгжих хугацаанд	-



		Мониторингийн хяналтын цэгийг тогтоож тогтмол хяналт тавих				
2.	Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	2.0	Төслийн бүх үе шатанд	Амьтны тухай хууль
		Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш		Төслийн бүх үе шатанд	Усны тухай хууль
		Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш		Төслийн бүх үе шатанд	-
3.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөны хүрээнд	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөны хүрээнд 2024 онд 500 ширхэг мод, суулгацыг тариалахаар төлөвлөв.	Тухайн орон нутгийн хэмжээнд	3.0	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	-
Нийт зардал				7.0		



5.7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

5.8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Алтай-Голд” ХХК-ийн “Харгуйтын баруун салаа”-ны алтны шороон ордын хайгуулын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтанд ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Цэнхэр сумын ЗДТГ, Цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.



5.9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд олборлосон элсийг уурхайн талбайд скруберээр баяжуулна. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 13.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Бүх ажилчдад гал түймэр унтраах сургалт зохион байгуулна Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулна Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулна	ШТС, гал тогоо, засварын газар, карьер ыолон технологийн гадаад догоод замууд, Уурхайн нийт ажилчид, албан хаагч ид хамрагдана			1,0	Төсөл хэрэгжих явцад	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй: Дуу чимээ болон ерөнхий аюулгүй байдлын аардлагуудын стандарт, MNS 5010:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй: гадна хог хаягдалд анализ хийх ерөнхий шаардлага, MNS 4284:95 XXCC, Галын аюултай бодис, материал. Ангилал, MNS 4244:94 XXCC, Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага
		6		0.05	0.3			
				-	Ү/а-ны зардал			
				-	2,0			
2.	Олборлолтын явцад тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх,	Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай ширүүн бороотой үед уурхайн ажлыг түр зогсооно. Уурхайн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт оруулна.						
3.	Уурхайн ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Уурхайн ажилчдад мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар сургалт зохион байгуулна. Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариагаар хангана.		1		Ү/а-ны зардлаар		
4.	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваарь гарах	Уурхайн ажилчдыг ажлын хувцас, хөдөлмөр хамгаалах хэрэгслэлээр хангана. Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах - Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад				Ү/а-ны зардал		
		Нийт зардал				3.3		



5.10 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг бид төлөвлөж байна.

- Уурхайн ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах, байгаль орчноо хайрлах, хамгаалах талаар сургалт зохион байгуулна.
- Сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан, зөвшөөрөл авч, ахуйгаас гарч байгаа энгийн, хатуу, шингэн хог хаягдлыг түр цэгүүдийг тогтоолгож, хуримтлуулан, сумын нэгдсэн хогийн цэгт нийлүүлнэ.
- Ахуйн болон аюултай хог хаягдлын талаар тогтмол бүртгэл хөтлөн, нэгдсэн дүнг сум орон нутгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.
- ШТС-ын орчим болон аюултай хог хаягдал хадгалах цэгийн талбайг 5 см хүртэл зузаантай цементэн хучлагаар хучих нь ажлын явцад ШТМ болон тос масло асгарах, дусах зэргээр хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлнэ
- Засварын цех, хүнд машин механизм, техник хэрэгслээс гарсан хаягдал тосыг түр хугацаанд битүүмжлэл сайтай саванд хадгалж хаягдал тос боловсруулдаг компанитай гэрээ байгуулан нийлүүлнэ.
- Төмрийн хог хаягдал, ахуйн хог хаягдал, шингэн хог хаягдал зэргээр хогийн цэгийг ангилан ялгаж тохижуулах.
- Стандартын шаардлага хангасан эко жорлон нэвтрүүлэх, бохирын үнэрийг дарах, үнэргүйжүүлэх, задлагч бодис ашиглана.

Хүснэгт 14.

Уурхайгаас сард ялгарах ахуйн бохирын тооцоо

Өгөгдөл	Хэмжээ	Шалгуур
Хугацаа	30 хоног	Нэг сараар тооцсон
Хүний тоо	50	Уурхайн ажилчдын тоо
Хүний нэг өдөрт ялгаруулах өтгөний хэмжээ	200 гр	Дэлхийн эрүүл мэндийн газрын гаргасан тооцоо
Хүний нэг өдөрт гаргах шингэн хаягдлын хэмжээ	1.5 л	
Тооцоо: $30 \times 50 \times 0,2 = 300$ кг $30 \times 50 \times 1,5 \text{ л} = 2250$ л $300 + 2250 = 2550 = 2,5 \text{ м}^3$		



Дээрхи тооцооноос харахад тус уурхай сард $2,5 \text{ м}^3$ ахуйн бохир гаргах бөгөөд сар тутамд “Ариусан” бэлдмэлийг сард 20 ш авч шингэрүүлэн цацаж ахуйн бохирыг задлах ажлыг биологийн аргаар хийхээр төлөвлөөд байна. Бэлдмэлийн зардал нь 200 000 төгрөг/жил болж байна.

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Сум орон нутагтаа хогны гэрээгээ шинэчлэн, хатуу шингэн хогийн цэгээ тогтоолгож, түр хадгалах зөвшөөрөл авна. Хогны төлбөрөө төлнө	Уурхайн тосгон, гал тогоо, оффис, халуун ус	жил	8.0	1	1,0	Төсөл хэрэгжих хугацаанд Төсөл хэрэгжих явцад	Ногоон хөгжлийн бодлого, 2014, Хог хаягдлын тухай хууль, 2017, Эрүүл тахуйн тухай хууль, 2017, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2006, “Нүхэн жорлон, бохир усны нүх MNS 5924-2008 стандартын шаардлага хангасан нүхэн жорлон байгуулах
						2.0			
						0.3			
						0.5			
						-			
						Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав			
						Удирдлага зохион байгуулалтын зардалд тусгав			
2.	Үйлдвэрийн	<ul style="list-style-type: none"> Уурхайн үйлдвэрийн явцад гарсан хог хаягдлыг хуримтлуулан бүртгэл хөтөлнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> Ашигласан дугуйг орон нутгийн хэрэгцээнд өгөх, уурхайн тохижилт, замын тэмдэг тэмдэглэгээний суурь болгон ашиглах Ашиглалтын явцад хаягдсан машин механизмаас гарсан төмрийн хаягдлыг цуглуулан, хаягдал төмрийг боловсруулдаг компанид өгөх, эсвэл орон нутгаас хаях зөвшөөрөл авах Үйлдвэрийн явцад гарсан хаягдлаас үүдэн хөрс, ус бохирдохоос урьдчилан сэргийлж хяналт шинжилгээ хийх 	Засварын газар, агуулах, карьер				Дотоод зардлаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав		
3.	Аюултай	Аюултай хог хаягдлыг тусад нь ялган, түр хадгална. Аюултай хог хаягдлыг дараах байдлаар ялгаж болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> Оффис: ашиглагдсан принтер, хор, баттерей, цахилгаан бараанууд Ахуйгаас: төрөл бүрийн будаг, лак Машин механизм: түлш, масло, тос, гидрийн шингэнүүд, масло, тосны шүүрнүүд, аккумуляторууд 	ШТС, оффис, сэлбэгийн агуулах, засварын газар					Дотоод зардлаар	
		Аюултай хог хаягдлын талаар бүртгэл мэдээлэл хөтөлж, сум орон нутгийн холбогдох байгууллагад мэдэгдэх							
		Ашигласан хаягдал тос масло авдаг компанитай гэрээ байгуулан тогтоосон хугацаанд нь нийлүүлэх							1.0
		Нийт зардал					4,8		



5.11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Тус компани нь Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй 2019 оноос эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд агаар, ус хөрсний чанарын шинжилгээнүүдийг хийнэ.

Хүснэгт 16.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	8
Агаарын чанарын шинжилгээ							
1.	Агаарын чанарын хяналт, Нийт тоос-Р ₁₀ , РМ _{2.5} , NO ₂ , SO ₂ СО-ын агууламж, дуу чимээ	Карьерын орчим, гадаад зам, уурхайн тосгон	6,8,10 сарууд	3 цэг	80,0	720,0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга, БОАЖС-ын 2011.10.10, А-342 хавсралт
Агаарын чанарын шинжилгээний нийт зардал						720,0	
Газрын гадарга							
1.	Газрын гадаргын эвдрэл: Хяналтын цэг тогтоож, уурхайн талбайн талбай дахь байгууламжуудад хэмжилт хийж, эвдэрсэн газрын хэмжээг гаргах	1.Төслийн талбай дахь газрын эвдрэл, овоолго бүр дээр хэмжилт, бичигдэл хийх	Төсөл хэрэгж их явцад				Хээрийн хэмжилт, ажиглалт хийж, холбогдох геодезийн хэмжилтүүдийг хийж, газарзүйн мэдээллийн системд оруулан нэгтгэх



**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ**

2.	Газрын гадаргын хэлбэрийн тогтворжилтын үзүүлэлтүүд: Хажуугийн өнцгийн чийгшил, ширхэгийн бүрэлдэхүүн	Бүх төрлийн овоолгуудад	Жилд нэг удаа				Хээрийн хэмжилт, ажиглалт хийж, холбогдох геодезийн хэмжилтүүдийг хийж, газарзүйн мэдээллийн системд оруулан нэгтгэх
3.	Техникийн нөхөн сэргээлтийн шалгуур үзүүлэлтүүдийг хангах байдлыг хянах, хэлбэршүүлэлтийн налуу, нөхөн дүүргэлт, гадаргуугийн тэгшилтгээнд хяналт тавих	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт	Жилд нэг удаа				
Газрын доор ус, усны чанарын шинжилгээ							
1.	Усны ерөнхий химийн шинжилгээ. (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, цахилгаан дамжуулах чанар, булингар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃), Ca, Mg, Na+K, HCO ₃ , Эрдэсжилт,	Хаягдлын сангийн бохир ус, голын ус	6, 7, 8, 9 сарууд	2 цэг	70,0	560,0	Байгаль орчин. Хүний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, Ундны ус, эрүүл ахуйн шаардлага ба чанарын хяналт MNS 4943:2015 Усны чанар. Хаягдал ус MNS 4586:1998 Усны байгаль орчны чанар, Ерөнхий шаардлага MNS 0899:1992 Ус хангамжийн эх үүсвэрийг сонгох дүрэм ба шаардлага болон эрүүл ахуйн шаардлага MNS 3936:1986 Ундны ус. Хээрийн нөхцөлд сорьц авах ба шинжлэх арга MNS 3342:1982 Хөрсний ус хамгаалах ерөнхий шаардлага MNS 0017-1-1-14:1980 Уст мандал. Усны ашиглалтын ангилал. Ерөнхий шаардлага MNS 4079:1988 Усны чанарын нэр томъёо ба тодорхойлолт, MNS 0900: 2005 "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ"
		Ундны усны эх үүсвэр, ус хадгалах сав,		2 цэг	70,0	560,0	
	Хүнд металл тодорхойлох, Pb, As, CN, Hg	Хаягдлын нуурын бохир ус, голын ус	5,9 сарууд	2 цэг	32,0	128,0	
	Микробиологийн шинжилгээ /5 үзүүлэлт	Ундны ус, ахуйн бохир ус, хаягдлын сан, голын ус,	6,8,10	4цэг	25,0	300,0	
	Усны чанарын шинжилгээний нийт зардал						
Амьтны аймаг							
1.	Туруутан амьтдын тоо, толгой шилжилт хөдөлгөөнийг тогтоох, тандалт хийх		Жилд нэг удаа			Ү/-ны зардал	
Хөрсний чанарын шинжилгээ							
1.	Агрохимийн үзүүлэлтүүд, хөрсний рН, чийг, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅ , цацраг	Шимт хөрсний овоолго, карьер, уурхайн тосгон	5,7,9 Сарууд, бохирдол үүссэн бол тухай бүрд	3 цэг	48,9	293.4	MNS 3342:1982 Хөрсний ус хамгаалах ерөнхий шаардлага MNS 5914:2008 Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нөхцөл болзол байдлын тодорхойлолт MNS 5915:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрын ангилал
	Нефтийн бүтээгдэхүүн	Карьер, шатахуун		3 цэг	50,0	450,0	



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАРГУЙТЫН БАРУУН САЛААНЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨ

	хадгалах сав, засварын газар						MNS 5916:2008 Байгаль орчин. Үр шимтэй хөрсийг зайлуулахад тавигдах шаардлага ба хөрсийг ухах хугацаанд түр хадгалах
Хүнд металл, Pb, As, CN, Hg	Карьер, засвар, ШТС	7, 10 сарууд	3 цэг	24,0	144.0		MNS 5917:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсний микробиологийн шинжилгээ	Карьер, ахуйн бохир ус, нүхэн жорлонгийн орчим	7, 10 сарууд	3 цэг	30,0	180.0		MNS 4920:2000 Байгаль орчин. Элдэгдсэн газрын налуу. Техникийн шаардлага
Хөрсний чанарын шинжилгээний нийт зардал					1,067.4		MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамалыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт					3,335.4		

Жич: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 05 сарын 06 –ны өдрийн А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



5.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 17.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан
			2024 он		
	1	2	3	4	5
1.	Байгаль орчны талаар баримтлах бодлого, Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр компанийн дотоод бодлогын баримт бичиг боловсруулах	0.57	+		Компанийн захирал, уурхайн дарга, байгаль орчны мэргэжилтэн
2.	Газрын тухай хуулийн 58.5 заасны дагуу Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гэрээний хугацаанд	+		Компанийн захирал байгаль орчны мэргэжилтэн
3.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх			+	Компанийн захирал байгаль орчны мэргэжилтэн
4.	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Төслийн хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд тохиролцох			Компанийн захирал, уурхайн дарга, байгаль орчны мэргэжилтэн
	Нийт зардал	0.5			



5.13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

Хүснэгт 18.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь /2024 он/

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн захиргааны төв байгууллагад /БОАЖЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тухай	2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч	Тайланг бичгээр хүргүүлнэ
2.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн сум, багийн ИТХ-д	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулаж танилцуулах		2024 оны 11 дүгээр сарын 10-ны дотор	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж, санал авах	Төсөл хэрэгжүүлэгч	Сум, багийн төв
3.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх		2024 оны 11 дүгээр сарын 10-ны дотор	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж, санал авах	Төсөл хэрэгжүүлэгч	Сумын төв



5.14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Хүснэгт 19

Д.д	Зардлын утга	Нийт зардал, сая.төг
1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1.33
2.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	4.7
3.	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	11.2
4.	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	3.0
5.	Нөхөн сэргээлтийн зардалд	2,0
6.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зардал	7,0
7.	Осол, эрсдлийн менежментийн зардал	3.3
8.	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	3.6
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3.3
10.	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	0.57
	Нийт зардлын дүн	40.00

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **40.00** сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.